

### **3.1. ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНД ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ**

Аймгийн Засаг дарга Яамны сайд нартай байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээг Засаг даргын Тамгын газрын хэлтэс, тасаг, ажилтнууд, агентлагуудын дарга, сумын Засаг дарга нартай байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээнд тусган биелэлтийг нь хагас, бүтэн жилээр тооцож ажиллаа.

Тайлант оны хагас жилээр бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээнд аймгийн Засаг даргын нэрэмжит үзлэг, хяналт шинжилгээг хийж хэрэгжилт удааширалтай зорилт заалтыг эрчимжүүлэх талаар аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар асуудал оруулан холбогдох шийдвэрийг гаргуулан ажиллаа.

Мөн салбарын сайдуудтай байгуулсан гэрээнд гүйцэтгэлийн хяналт шинжилгээ хийж, тайланг холбогдох газруудад тус тус хүргүүллээ.

Яамны сайд нартай байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээг оновчтой зохион байгуулж ажилласны дүнд БСШУЯ-ны 5 ангийн 12 бүтээгдэхүүнийг 100 хувиар, ЭМЯ-ны 6 ангийн 15 бүтээгдэхүүнийг 89.5 хувиар, БХЯ-ны 4 ангийн 17 бүтээгдэхүүнийг 98.5 хувиар, Тэргүүн шадар Сайдын 5 ангийн 5 бүтээгдэхүүнийг 100 хувиар, Шадар сайдын 12 ангийн 384 бүтээгдэхүүнийг 97.6 хувиар, НХХЯ-ны 5 ангийн 41 бүтээгдэхүүнийг 97.4 хувиар, ХЗДХЯ-ны 5 ангийн 31 бүтээгдэхүүнийг 98.7 хувиар, БОАЖЯ-ны 4 ангийн 4 бүтээгдэхүүнийг 100 хувиар, Үндэсний статистикийн хорооны 4 ангийн 17 бүтээгдэхүүнийг 89.9 хувиар, ХХААХҮЯ-ны 5 ангийн 16 бүтээгдэхүүнийг 100 хувиар тус тус биелүүллээ.

Дэлхийн эдийн засгийн хямрал, төсвийн хүрэлцээгүй байдал тухайн онд нийлүүлэх бүтээгдэхүүний биелэлтэнд нөлөөлсөн хэдий ч орон нутгийн төсвийн хөрөнгийн нөөц боломжийг бүрэн дүүрэн ашигласны дүнд Яам, тусгай газрын нийт 55 ангийн 542 бүтээгдэхүүнийг дундаар **91** хувиар биелүүлсэн нь гэрээнд заасан үүргээ 6 хувиар давуулан биелүүлсэн байна.